

“ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ” ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын “ЭМТ НАРАН” ОНӨААТҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2022/03/НА-СА-ОНА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Дархан-Уул аймаг  
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр  
Утас: 7037-3089  
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Батцэцэг  
Утас: 7037-3089  
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай аудит” ХХК  
Захирал : Ж.Бямбажав  
Цахим хаяг: dum\_audit@yahoo.com  
Утас: 11-325262  
Утас: 91991462

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал.....	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
8. Аудитын илрүүлэлт.....	14

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,  
Дархан сум, 14-р баг  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
E-mail: darkhanuul@audit.gov.mn

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР  
СУМЫН “ЭМТ НАРАН” ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА Д.АРИУНБОЛД ТАНАА**

2022.03.15 № 239

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**



**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эмт наран ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эмт наран ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон зүйл**

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 98.1 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан зардлын гүйцэтгэл 106.6 хувийн биелэлттэй байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

**Бусад асуудал**

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа бэлтгэхдээ тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ.

009020316

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ.

Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,842,430.69	55,953,458.31
1.1.2	Дансны авлага	81,329,484.47	31,562,845.19
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	568,153.28	299,776.08
1.1.6	Бараа материал	45,569,601.57	56,817,263.44
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>136,309,670.01</b>	<b>144,633,343.02</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,965,288,377.04	2,127,417,402.65
1.2.2	Биет бус хөрөнгө	191,834,000.17	191,834,000.17
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,157,122,377.21</b>	<b>2,319,251,402.82</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,293,432,047.22</b>	<b>2,463,884,745.84</b>
2.1.1.1	Дансны өглөг	5,832,413.15	2,694,187.04
2.1.1.3	Татварын өр	7,638,606.49	9,946,572.91
2.1.1.4	НДШ-ийн өглөг	80,693.00	-
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>13,551,712.64</b>	<b>12,640,759.95</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>13,551,712.64</b>	<b>12,640,759.95</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	945,252,479.20	945,252,479.20
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	664,681,823.03	664,681,823.03
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,517,794,125.80	1,883,584,125.80
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(847,848,093.45)	(1,042,274,442.14)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>2,279,880,334.58</b>	<b>2,451,243,985.89</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,293,432,047.22</b>	<b>2,463,884,745.84</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>490,815,124.12</b>	<b>458,620,226.56</b>
2	Борлуулалтын өртөг	183,525,377.03	155,222,595.91
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>307,289,747.09</b>	<b>303,397,630.65</b>
8	Бусад орлого	117,388,600.00	208,688,477.27
9	Борлуулалт, маркетингийн зардал	575,248,961.44	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	575,161,214.44	706,302,731.16
11	Санхүүгийн зардал	-	72,400.00
12	Бусад зардал	87,747.00	137,325.45
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(6,721,938.95)	-
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(157,292,553.30)</b>	<b>(194,426,348.69)</b>
19	Орлогын татварын зардал		
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(157,292,553.30)</b>	<b>(194,426,348.69)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(157,292,553.30)</b>	<b>(194,426,348.69)</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(157,292,553.30)</b>	<b>(194,426,348.69)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан  
/тегрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	1,517,794,125.80	(690,555,540.15)	2,437,172,887.88
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	1,517,794,125.80	(690,555,540.15)	2,437,172,887.88
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(157,292,553.3)	(157,292,553.3)
5	Бусад дэлгэрэнгүй орлого			-		-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-				-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2020 ний 01 сарын 01-ний үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	1,517,794,125.80	(847,848,093.45)	2,279,880,334.58
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
11	Залруулсан үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	1,517,794,125.80	(847,848,093.45)	2,279,880,334.58
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(194,426,348.69)	(194,426,348.69)
13	Бусад дэлгэрэнгүй орлого			-		-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-		365,790,000.00		365,790,000.00
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
17	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	1,883,584,125.80	(1,042,274,442.14)	2,451,243,985.89

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>630,884,465.79</b>	<b>768,790,291.28</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	428,815,674.25	572,094,691.28
	Татаас, санхүүжилтийн орлого	117,388,600.00	112,338,600.00
	Бусад мөнгөн орлого	84,680,191.54	84,357,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>625,941,354.60</b>	<b>703,924,900.02</b>
	Ажиллагчдад төлсөн	230,056,372.83	261,373,943.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	81,773,779.35	86,484,863.13
	Бараа материал худалдан авахад төлсөн	162,280,858.00	194,954,264.98
	Ашиглалтын зардалд төлсөн	53,064,751.00	59,613,631.82
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,738,300.00	7,093,909.09
	Татварын байгууллагад төлсөн	52,407,170.25	74,034,917.03
	Даатгалын төлбөрт төлсөн	-	6,349,960.04
	Бусад мөнгөн зарлага	41,620,123.17	14,019,410.93
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>4,943,111.19</b>	<b>64,865,391.26</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	17,754,363.64
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	17,754,363.64
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	<b>(17,754,363.64)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>4,943,111.19</b>	<b>47,111,027.62</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,899,319.50</b>	<b>8,842,430.69</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>8,842,430.69</b>	<b>55,953,458.31</b>

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/ төгрөгөөр/

№	Дансны нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт
А	Б	1	2	3
1	Дулааны борлуулалт	430,000,000.00	392,054,355.45	37,945,644.55
2	Усны орлого	58,000,000.00	66,565,871.11	(8,565,871.11)
3	Татаас, санхүүжилт	112,388,600.00	112,388,600.00	0.00
4	Бусад орлого	87,300,000.00	96,299,877.27	(8,999,877.27)
	<b>Нийт орлого</b>	<b>687,688,600.00</b>	<b>667,308,703.83</b>	<b>(20,379,896.17)</b>
5	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	120,000,000.00	101,031,443.28	18,968,556.72
6	Банкны шимтгэл	50,000.00	93,400.00	(43,400.00)
7	Үйл ажиллагааны бус бусад зардал		137,325.45	(137,325.45)
8	Үндсэн цалин	324,000,000.00	320,643,567.00	3,356,433.00
9	1 удаагийн тэтгэмж	1,000,000.00	1,449,852.00	(449,852.00)
10	Шагнал	1,200,000.00	103,746.00	1,096,254.00
11	ХЧТүр алдсны тэтгэмж	1,500,000.00	573,063.00	926,937.00
12	НДШ-ийн зардал	46,980,000.00	48,461,689.13	(1,481,689.13)
13	Засвар, үйлчилгээний зардал	13,000,000.00	22,440,310.07	(9,440,310.07)
14	Шинжилгээний зардал	1,500,000.00	1,117,672.73	382,327.27
15	Гэрэл цахилгааны зардал	50,000,000.00	59,213,631.82	(9,213,631.82)
16	Нүүрсний пүүний зардал	200,000.00	0.00	200,000.00
17	Интернэтийн зардал	510,000.00	239,863.63	270,136.37
18	Үйлчилгээний зардал	4,600,000.00	4,799,179.55	(199,179.55)
19	Сургалтын зардал	2,500,000.00	327,727.32	2,172,272.68
20	Нормын сүүний зардал	1,500,000.00	1,547,496.60	(47,496.60)
21	Дотоод томилолтын зардал	1,000,000.00	268,000.00	732,000.00
22	Цай, хүлээн авалтын зардал	240,000.00	280,000.00	(40,000.00)
23	Тээврийн зардал	1,000,000.00	13,923,600.00	(12,923,600.00)
24	Элэгдлийн зардал	210,000,000.00	221,415,338.03	(11,415,338.03)
25	Гүйцэтгэх ажилтны гар утасны зардал	990,000.00	981,818.81	8,181.19
26	Шатахууны зардал	9,500,000.00	7,552,171.51	1,947,828.49
27	Үйл ажиллагааны бусад зардал	7,000,000.00	13,821,809.33	(6,821,809.33)
28	Бичиг хэргийн зардал	1,500,000.00	1,143,160.33	356,839.67
29	Ариун цэврийн зардал	320,000.00	3,136,469.58	(2,816,469.58)
30	Акталсан хөрөнгө		23,270,820.96	(23,270,820.96)
31	Машины татварын зардал	300,000.00	239,500.00	60,500.00
32	Үл хөдлөх хөрөнгийн татварын зардал	1,456,000.00	1,370,878.29	85,121.71
33	Газрын төлбөр	176,100.00	1,061,363.81	(885,263.81)
34	Агаарын бохирдлын татварын зардал		67,500.00	(67,500.00)
35	Ус рашаан ашигласны татвар	269,000.00	268,377.20	622.80
36	Хөдөлмөр хамгааллын зардал	5,500,000.00	10,775,277.10	(5,275,277.10)
	<b>дүн</b>	<b>807,791,100.00</b>	<b>861,756,052.52</b>	<b>(53,964,952.52)</b>
	Ашиг/ алдагдал/	(120,102,500.00)	(194,447,348.69)	74,344,848.69

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эмт наран ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллагын дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад цалин, татвар, даатгал, орлого, санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 10-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Дундманхайдай Аудит ХХК-ийн захирал Ж.Бямбажав хянан удирдаж, чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, аудитор С.Батжаргал, аудиторын туслах С.Ариунтунгалаг нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эмт наран ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг “Дундманхайдай аудит” ХХК-д 2022 оны 01 дугаар сарын 25-ний өдрийн 11 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эмт наран ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эмт наран ОНӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу 2021 онд “Дарханы зөвлөх боломж төв” -өөр боловсруулан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх шаардлагад нийцсэн байна.

Тайланд хугацаанд Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эмт наран ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны дэлгэрэнгүй орлогын тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны дэлгэрэнгүй орлогын тайлангийн нийт зардлын 861.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 12.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эмт наран ОНӨААТҮГ-ын зорилго нь Хонгор сумын иргэдийг дулаан болон цэвэр усаар хангахад оршино. Байгууллагын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дулаан үйлдвэрлэх түгээх, цэвэр ус татах түгээх, бохир ус татан зайлуулах гэж тодорхойлжээ.

Тус байгууллага нь “ОНӨААТҮГ” гэсэн статустай бөгөөд 100 хувь орон нутгийн өмчит харьяалагдаж байна.

### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эмт наран ОНӨААТҮГ нь Хонгор сумын ИТХ-н 2008 онд 42 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эмт наран ОНӨААТҮГ-ын удирдлагыг сумын засаг дарга томилж 895,945.00 төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд өмч хамгааллын байнгын комисс байгууллагын өмчийн тооллого үзлэгийг хагас жилд 1 удаа явуулах ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж, ажлын тайланг Аймгийн өмчийн газарт тайлангаа хүргүүлэн ажилласан байна. Мөн эзэмшилд буй газрыг дахин үнэлэн балансад тусгасан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг

хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал зардлыг гаргахгүй байх,-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж 4 орон тоог бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан төрийн үйлчилгээний цалин хөлсний шатлалаар тогтоосон хэмнэлт гарган ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эмт наран ОНӨААТҮГ -ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31	Өөрчлөлт
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,842.4	55,932.5	47,090.0
1.1.2	Дансны авлага	81,329.5	31,562.8	(49,766.6)
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	568.2	299.8	(268.4)
1.1.6	Бараа материал	45,569.6	56,817.3	11,247.7
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	136,309.7	144,633.3	8,302.7
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,965,288.4	2,127,417.4	162,129.0
1.2.2	Биет бус хөрөнгө	191,834.0	191,834.0	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,157,122.4	2,319,251.4	162,129.0
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,293,432.0</b>	<b>2,463,884.7</b>	<b>170,431.7</b>
2.1.1.1	Дансны өглөг	5,832.4	2,694.2	(3,138.2)
2.1.1.3	Татварын өр	7,638.6	9,946.6	2,308.0
2.1.1.4	НДШ-ийн өглөг	80.7	-	(80.7)
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,551.7	12,640.8	(911.0)
2.2	Өр төлбөрийн нийт дүн	13,551.7	12,640.8	(911.0)
2.3.1	Өмч: - төрийн	945,252.5	945,252.5	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	664,681.8	664,681.8	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,517,794.1	1,883,584.1	365,790.0
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(847,848.1)	(1,042,274.4)	(194,426.3)
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,279,880.3	2,451,244.0	171,342.7
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,293,432.0</b>	<b>2,463,884.7</b>	<b>170,431.7</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 55,932.4 мянган төгрөг болж, 47,090.0 мянган төгрөгөөр өссөн нь оны эхний авлагаа барагдуулснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 31,792.6 мянган төгрөг болж, 50,105.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны төсвийн байгууллагуудын авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 56,817.3 мянган төгрөг болж, 11,247.7 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын үнэ ханш өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,319,251.4 мянган төгрөг болж, 162,129.0 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангаас үнэ төлбөргүй хөрөнгө авсан. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 17,754.3 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 365,790.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 12,640.7 мянган төгрөг болж, 911.0 мянган төгрөгөөр буурсан нь худалдан авсан бараа материалын өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн 1,042,274.4 мянган төгрөг болж 194,426.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Өмнөх онтой харьцуулахад зардал 53.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бараа материалын үнэ, цахилгаан хэрэглээний өсөлт зэргээс шалтгаалжээ.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу төрийн өмчийн хадгалалт хамгаалалт ашиглалтыг хангах үйл ажиллагааг тасралтгүй тогтвортой явуулах зорилгоор байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус байгууллага 2021 оны 01 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 687.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 807.0 сая төгрөгөөр, 120.1 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 667.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 861.7 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагаанд зарцуулан, 194.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 667.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 20.4 сая төгрөг буюу 2.9 хувиар тасарсан нь дулааны борлуулалт тасалдсанаас шалтгаалжээ. Энэ нь төсвийн байгууллагууд зардлаа хэмнэн ажилласантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 861.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 53.0 сая төгрөг буюу 6 хувиар өссөн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу засвар үйлчилгээний ажилд өөрийн эх үүсвэрээс 22.4 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 194.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 74.3 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн нэгжүүд цахилгааны хэрэглээ нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэл зохицуулалттай.

Тус байгууллага нь тайлант онд нийт 1 277,5 мянган төгрөгийн 164 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулан, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага нь голлох бараа материал, нүүрс худалдан авах нээлттэй тендерийг 2 удаа зарласан боловч оролцогч ирээгүй учир шууд худалдан авалтын гэрээг Шарын гол ХК, Монничикон ХХК, иргэн Д.Болдсайхан нартай байгуулан нүүрс худалдан авч ажилласан байна.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,580.0 мянган төгрөгийн албан шаардлагын биелэлтийг ханган, 40.0 мянган төгрөгийн 1 актыг барагдуулан, 2,082.7 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна. Аудитаар өгсөн нийт 3,702.7 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		/мянган төгрөг/ Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Төлбөрийн акт	1	40.0	1	40.0			
Албан шаардлага	1	1,580.0	1	1,580.0			
Зөвлөмж	4	2,082.7	4	2,082.7			
Нийт дүн	6	3,702.7	6	3,702.7			

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 848.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 60.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 788.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 848.2 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшний 12,926.0 мянган төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулгыг хийгээгүй болно.

### 8.2 Төлбөрийн акт

Аудитаар 60,000.00 төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Үүнд:

Кассын тайлангаар дараа тайлангаар 60,000.00 төгрөгийн хүнс, засварын материал авсан нь нотлох дэмжих үндсэн баримтгүй, И баримтаар баталгаажаагүй, мөнгөний зарцуулалтыг тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтууд, "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, эрхзүйн актыг мөрдөх, төлбөрийн акт тогтоов.

### 8.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Цалинтай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Тайлант 27 албан хаагчид нийт 97,783.13 төгрөгийн ХХОАТ-ыг илүү суутгаж, гарт олгох цалинг дутуу олгосон байна. Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараахь хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ:" гэсэнтэй нийцэхгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримт, тайланд үндэслэн холбогдох мэдээ, тайланг үнэн зөв тооцон хянаж байх.

#### 2. Цалинтай холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын хувь хэмжээг буруу тооцсон нийт 16 хүний 134,150.95 төгрөгийг дутуу суутгасан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан

шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 3/нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын хууль мөрдөж ажиллах.

### **3. Шилэн данстай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Тус байгууллага нь тайлант онд нийт 1,277.500.00 төгрөгийн 164 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулан, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн мөрдөн ажиллах.

### **4. Бараа материалтай данстай холбоотой асуудал**

4.1. Илрүүлэлт:

Нүүрс зарцуулалтын тайлангаар галлагаанд хэрэглэсэн өдөр тутмын нүүрсний тооцоог галч нар баталгаажилт хангаагүй,тайлан тооцоог хянаж тайлагнаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалт,"Үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримт, тайланг үнэн зөв тооцон хянаж байх.

### **5. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

5.1. Илрүүлэлт:

Кассын тайлангаар 124,000.00 төгрөг шинжилгээний төлбөрт олгосон бэлэн мөнгөний зарцуулалтыг тайлагнаагүй, хамрагдсан ажилчдын гарын үсэг баталгаажилтгүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах",6.4.8 дахь"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх",НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтууд , "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна

5.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг ханган зарцуулалтыг гаргаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дархан-Уул аймгийн Хонгор сумын ЭМТ НАРАН ОНӨААТҮГ	6	848.2	-	-	1	60.0	-	-	5	788.2
	<b>Дүн</b>	6	848.2	-	-	1	60.0	-	-	5	788.2

Дундманхайдай аудит ХХК

Огноо: 2022.03.1